

Хорооног

“АВТО ЗАМ” ХК-ИЙН 2015 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ПРОТОКОЛ

2015.06.15.

Архангай. Эрдэнэ булган баг

Р.ГАНТӨМӨР: Товч тайлбар хурал хойшилсон талаар.

“Авто зам” ХК-ийн 2015 оны ээлжит хурлыг 4-р сарын 25-ны өдөр хуульд заасан хугацаанд нь зохих хууль, дүрэм, журмын дагуу бүхий л холбогдох материалыг бүрдүүлж Хөрөнгийн бирж, харьяа брокер, дилерийн нийт 20 компанид албан ёсоор хүргүүлсэн ба ялангуяа “Ажнай” группэд тусгайлан хүргүүлсэн болно. Гэвч хуралд нийт хувьцаа эзэмшигчдийн саналын эрхтэй хувьцааны 53,3 хувь буюу 74139 ширхэг хувьцаа эзэмшигч ирсэн байна. Гэвч хяналтын багцын хувьцаа эзэмшигч талын эрхийг хүндэтгэн тэдний санал зайлшгүй шаардлагатай тул тодорхой хугацаагаар хойшлуулсан болно.

“Компанийн тухай” хуулийн 69.3-т, мөн хуулийн 69.7-д заасны дагуу хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг хэвээр үлдээж, 2015 оны 6-р сарын 02-ны 6/02 тоот Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол гаргасан болно.

Хурал дахин зарласан 6-р сарын 15-ны 14 цагт мөн л урьдын адил саналын эрхтэй 53,3 хувийн ирцтэй учир хурлыг хуралдуулж зохих ёсны дагуу шийдвэр гаргаж Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулахын тулд, хувьцаа эзэмшигч бүрийн эрхийг хүндэтгэн үзэх үүднээс хурал хуралдаж шийдвэр гаргах нь зүйтэй байна.

1.Хурлыг ТУЗ-ийн дарга Р.Гантөмөр даргалж, тооллогын комисс Д.Самбууг томилж ирцийг танилцуулсан ба 74139 ширхэг хувьцаа эзэмшигч буюу 53,3 хувийн ирцтэй байв.

Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайланг гүйцэтгэх захирал Р.Нямдоржийн илтгэлийг сонсов. Илтгэлтэй холбогдуулж ямар нэгэн санал, асуулт, дүгнэлт гарсангүй.

2. Санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг компанийн ерөнхий нягтлан бодогч Д.Самбуу танилцуулсны дараа тайлантай холбогдуулан асуулт, хариулт явагдав.

Р.Гантөмөр: Асуулт

1. Өнгөрсөн онуудын хуримтлагдсан ашгийн зарцуулалт, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн зохих журам, дүрмийг хэрхэн чанд хэрэгжүүлж буй хувьцаа эзэмшигч нарт компанийн эдийн засгийн өгөөж, үр дүн, цаашилбал зардлын төрлөөр нь мөн мөнгөн хөрөнгө, бараа материалын дэлгэрэнгүй тайланг холбогдох баримт,

дансны гүйлгээ, кассын орлого, зарлага, компанийн хоорондын гэрээгээр гүйцэтгэсэн ажил үйлчилгээний төлбөр тооцоо нийлсэн акт гэх мэт олон зүйлийг цаашид ТУЗ-д танилцуулж санхүүгийн дотоод хяналтыг сайжруулах, ялангуяа анхан шатны баримтын бүртгэл хөтлөлтийг сайжруулж ажиллахыг анхааруулав.

2014 оны үйл ажиллагааны үр дүнд олсон ашгийг татвар төлсний дараахь цэвэр ашгийг хувьцааны ноогдол ашиг болгон хуваарилах санал дэвшүүлж, санал хураах горимын саналтай байна. Учир нь сүүлийн 2-3 жилд бага боловч тогтмол ашигтай ажилласан ба хувьцаанд ноогдол ашиг хуваарилсаны дараа компанийн санхүүгийн чадамж нь “Компанийн тухай” хуулийн 48-р зүйлийн 1.1, 3.1, 32.1 дүгээр заалтууд зөрчигдөхгүй байхаар байна. Ингээд саналын олонхоор нэгж ширхэг хувьцаанд 503 төгрөгөөр бодож ноогдол ашиг олгох санал дэмжигдэв.

3. ТУЗ-ийн нэр дэвшигчдийн танилцуулга яригдаж баталгаажуулах санал хураалт болж, нэр дэвшигдсэн хүмүүсийг санал нэгтэй батлав.


Р.ГАНТӨМӨР санал хэлж цаашид нэр дэвшсэн хараат гишүүд болон бусад төлөөлөлийг идэвхтэй оролцож ажиллах мөн шалтгаангүй хуралд ирээгүй хараат бус гишүүдийг нөхөн сонгон шалгаруулалт явуулж оролцуулах, мөн тэдний идэвхийг сайжруулах гол хүчин зүйл болох тогтоолоор баталгаажуулсан төсөв мөнгийг тухай бүр нь олгож, хагас жил, жилийн эцсийн тайлангийн хурлыг хугацаанд олгож байхаар тогтоолын төслийг баталж түүнийг хэрэгжүүлэхэд компанийн санхүүгийн болон нягтлан бодогч Д.Самбуу, гүйцэтгэх захирал Р.Нямдорж нарт үүрэг болгох саналыг дэвшүүлэв.

Компанийн 2015 оны зорилтод төлөвлөгөөг оруулж ирсэн төлөвлөгөөний дагуу санал байгаа эсэхийг тодруулж баталгаажуулав.

2015 оны ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурлын үйл явц өрнөлийг дүгнэж ТУЗ-ийн дарга Р.Гантөмөр үг хэлэв.

Энэ удаагийн ээлжит хуралд оролцсон хувьцаа эзэмшигч хүмүүст баярласнаа илэрхийлж та бүгд ялангуяа Хяналтын зөвлөлд сонгогдсон нэр бүхий хүмүүс цаашид идэвхтэй оролцож байх. Мөн компанийн одоогийн удирдаж буй хүмүүс компанийн үйл ажиллагааны чиглэлийг орон нутгийн нөхцөл байдалд уялдуулан өөрчлөх, санал санаачлагтай ажиллахыг хүсч байна. Ингээд та бүхэнд ажлын амжилт, эрүүл энхийг хүсье.

Протокол хөтөлсөн:



У.Нэргүй